



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 497

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 7.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нэгдүгээр хавсралтад заасан 120,215,626.00 (нэг зуун хорин сая хоёр зуун арван таван мянга зургаан зуун хорин зургаа) төгрөгийн балансын үнэ, хурумтлагдсан элэгдэл бүхий автомашины ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож Хил хамгаалах ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хоёрдугаар хавсралтад заасан 143,892,643.00 (нэг зуун дөчин гурван сая найман зуун ерэн хоёр мянга зургаан зуун дөчин гурван) төгрөгийн балансын үнэ, хурумтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож Орхон аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд дадлагын ажлын зориулалтаар балансаас балансад шилжүүлсүгэй.


3.Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн, Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Х.Бадамсүрэн, Орхон аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Төгсбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, автомашины улсын дугаарыг улсын бүртгэл, татвар төлөгчөөс бүртгэлээс хассан тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

132001589

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Наангэрэл)-т үүрэг болгосугай.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны дугаар сарын өдрийн
..... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖУУЛЭХ
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ**

д/д	Тээврийн хэрэгслийн нэр, улс, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, хуимтлагдсан элэгдэл (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээд	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Ашиглах хугацаа (жил)
1	Мерседес Бенз Спринтер, 315CDI, 85-58 OPX, арал-WDB9067331S424691	2010	120,215,626.00	Хил хамгаалах ерөнхий газар	10,000,000.00	1
НИЙТ ДҮН		(нэг зуун хорин сая хоёр зуун арван таван мянга зургаан зуун хорин зургаа)			(арван сая)	

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын

2021 оны 7..... дугаар сарын 1..... өдрийн

409 дугаар тогтоолын хөөрдугаар хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ**

д/д	Тээврийн хэрэгслийн улс, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээд	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Ашиглах хугацаа (жил)
1	Трактор "Камацу" WB93R, 02-26 УР арал- KMTWB003J77F25708	2004	143,892,643.00	Орхон аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	10,000,000.00	1
НИЙТ ДҮН			(нэг зуун дөчин гурван сая найман зуун ерэн хоёр мянга зургаан зуун дөчин гурав)		(арван сая)	